



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,

Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,

Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2025.08.28 № 654
танай _____-ы № _____-т

Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН Г
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТТУЯА ТАНАА

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

Аудитын код: ХЭА-2025/66-ШТА-НА

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Д.Эрдэнэтуяа

Утас: 99569599 Цахим хаяг: erdenetuyade@audit.gov.mn

Чингис хот
2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Ерөнхий зүйл	3
Бүлэг 1. Сонгуулийн зардлын данс бүртгүүлэх, хандив авах, зарцуулах үйл явц нь холбогдох хуульд нийцсэн байна.	5
1.1. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансаа бүрэн бүртгүүлж, дээд хэмжээнээс хэтэрсэн хандив аваагүй байна.	5
1.2. Сонгуулийн хандивыг хуулийн хүрээнд хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.	5
Бүлэг 2. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу тайлагнаж, харилцагч талууд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.	6
2.1. Нам, нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд бүрэн гаргаж ирүүлсэн байна.	6
2.2. Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг харилцагч талууд хууль, журмын дагуу гаргаж ирүүлсэн байна.	7
Аудитын дүгнэлт	8
Тайланг баталгаажуулсан тушаал	9

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх /ХЭА-2025/66-ШТА-НА/

Товчилсон үгийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГ	ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит

Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2025 оны А/82 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, дүн болон нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд чиглэсэн. Үүнд:

- ❖ Сонгуулийн зардлын санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулсан эсэх
- ❖ Сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу бүрэн тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн хувийн аудитын хуулийн этгээдийн дүгнэлт, банканд байршуулсан сонгуулийн зардлын дансны гүйлгээний хуулгыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн аудитын арга зүйг ашиглан баримт материалд үндэслэн тулган баталгаажуулалт хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгаж дүгнэлт гаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, хүлээн авах, нийтэд мэдээлэх, танилцуулах журам
- ❖ Зөрчлийн тухай хууль
- ❖ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа


Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Билэгсайхан, аудитор Д.Эрдэнэтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрөөс 8 дугаар сарын 18-ны өдрийн хооронд хийж төлөвлөгөөг батлуулсан.

Талбарын үе шатны ажлыг 2025 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хийж дуусган, тайлан, судалгаа, дүгнэлтийг 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд 6 сумын ИТХ-д Хэнтий аймгийн Монгол ардын намын 6 хороо, 7 нэр дэвшигч, Хэнтий аймгийн Ардчилсан намын 6 хороо 7 нэр дэвшигч, Хүн намын 1 хороо, 2 нэр дэвшигч сумдын Сонгуулийн хороонд бүртгүүлсэн байна.

Дүрслэл 1. Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон намын хорооны дансны мэдээлэл, тайлан ирүүлсэн байдал



Үүнээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т заасны дагуу нийт 5 намын хороо, 16 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.

Дүрслэл 2. Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн дансны мэдээлэл, тайлан ирүүлсэн байдал



Мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын хүрээнд 5 намын хороо, 16 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж ирүүлсэн байна.

Бүлэг 1. Сонгуулийн зардлын данс бүртгүүлэх, хандив авах, зарцуулах үйл явц нь холбогдох хуульд нийцсэн байна.

1.1. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансаа бүрэн бүртгүүлж, дээд хэмжээнээс хэтэрсэн хандив аваагүй байна.

Сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн хүрээнд сумдын сонгуулийн хороонд нийт 13 намын хороо бүртгүүлснээс 5 намын хороо нь зардлын дансаа бүртгүүлсэн байна.

Харин сумдын Сонгуулийн хороонд бүртгүүлсэн 16 нэр дэвшигч нь Хаан банк, Хас банк, Төрийн банканд сонгуулийн данс нээн, дансны дугаараа аймаг дахь Төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

Сонгуулийн зардлын санхүүжилтийг АНСДИТХСТХуулийн хүрээнд бүрдүүлж ажилласан бөгөөд нийт 2 нэр дэвшигч 350.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авсан байна. Энэ нь АНСДИТХСТХуулийн 55.1¹-т заасан хориглолтод хамаарахгүй байна.

Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгийн хүрээнд Хэнтий аймгийн Хүн намаас 2 нэр дэвшигчид нийтдээ 2,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон бол бусад нэр дэвшигчдэд харьяалах намаас санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй байна.

Нэр дэвшигчдэд АНСДИТХСТХуулийн 53.1²-т заасныг хэтрүүлэн хандив өгсөн иргэн, хуулийн этгээд байхгүй байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны сонгуульд нэр дэвшсэн 16 нэр дэвшигч мөнгөн бус хандиваар үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх гэрээг иргэн, хуулийн этгээдтэй байгуулаагүй байна.

1.2. Сонгуулийн хандивыг хуулийн хүрээнд хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

АНСДИТХСТХуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаанд 16 нэр дэвшигч 2,350.4 мянган төгрөгийг зарцуулж, 1 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс 0.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

¹ **55.1. Дараах этгээд хандив өгөхийг хориглоно:**

55.1.1. гадаад улс буюу гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

55.1.2. гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;

55.1.3. 18 нас хүрээгүй хүн;

55.1.4. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

55.1.5. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;

55.1.6. үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага.

² **53.1. Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна.**

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын зарцуулалт

д/д	Сонгуулийн зардлын ангилал	Зардал /мян.төг/	Хувь
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	998.0	42.5
2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	24.0	1.0
3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	50.0	2.1
4	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	1,274.8	54.2
5	Бусад зардал	3.6	0.2
	НИЙТ	2,350.4	

Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах болон сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал зэрэгт нийт зардлын 96.7 хувийг зарцуулсан байна.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/22 тушаалаар сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 26-31.3 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 12.4-37.6 сая төгрөг байхаар тус тус тогтоосныг хэтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч байхгүй байна.

Бүлэг 2. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу тайлагнаж, харилцагч талууд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.1. Нам, нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд бүрэн гаргаж ирүүлсэн байна.

АНСДИТХСТХуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу 5 намын хороо, 16 нэр дэвшигч хуулийн хугацаанд хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан зардлын тайлангаа ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын тайланг ирүүлсэн нэр дэвшигчдийн тоо

д/д	Намын нэр	Зардлын данс, банкны нэр бүртгүүлсэн нэр дэвшигчийн тоо	Зардлын тайлангаа баталгаажуулж ирүүлсэн нэр дэвшигчийн тоо
1	Ардчилсан нам	7	7
2	Монгол ардын нам	7	7
3	Хүн нам	2	2
	НИЙТ	16	16

Хуулийн дагуу хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/34 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 17.1-т заасны дагуу хавсралт маягтыг бүрэн гаргаж, орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт зэргийг бүрэн бүрдүүлж ирүүлсэн байна.

2.2. Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг харилцагч талууд хууль, журмын дагуу гаргаж ирүүлсэн байна.

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд нийт 3 хувийн аудитын хуулийн этгээд дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэсэн байна.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 20 дахь хэсэгт заасны дагуу ашиг сонирхлын хувьд нам, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан, ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдэгдэл, тайлбараа бүрэн гаргаж ирүүлсэн.

Хүснэгт 3. Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардалд дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээдийн судалгаа

д/д	Хувийн аудитын хуулийн этгээдийн нэр	Дүгнэлт гаргуулсан		Мэдэгдэл тайлбар гаргасан эсэх
		Намын тоо	Нэр дэвшигчийн тоо	
1	“Ай Жи Эй Эйч-Аудит” ХХК	3	6	Тийм
2	“Нью капитал тэнцэл аудит” ХХК		1	Тийм
3	“Өндөрхаан итгэл-аудит” ХХК	2	9	Тийм
	Нийт	5	16	

Аймаг дахь Төрийн аудитын газраас Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг сануулж, сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн нэр дэвшигчдийн судалгааг хавсарган тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Голомт банк, Төрийн банк, Хаан банк, Хас банкны салбаруудад албан бичгийг 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн.

Үүний дагуу Төрийн банк, Хаан банк, Хас банкнаас нам, нэр дэвшигчийн дансны хуулгыг гарган хуулийн хугацаанд багтаан ирүүлсэн байна.

Аудитын дүгнэлт

- ✓ Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансаа Төрийн аудитын байгууллагад бүртгүүлэх үүргээ биелүүлж ажилласан байна.
- ✓ Иргэн, хуулийн этгээдээс нэр дэвшигчдэд өгсөн хандив нь сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрээгүй байна.
- ✓ Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд бүрэн ирүүлсэн байна.
- ✓ Төрийн банк, Хаан банк, Хас банкны Хэнтий салбар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайланг баталгаажуулсан тушаал



2025 оны 08 дугаар сарын 27

Дугаар А/37

Чингис хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт хүргүүлж, олон нийтэд мэдээлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилтийн дүн

/мян.төг/

№	сум	Намын нэр	Нэр дэвшигчийн		Нэр дэвшсэн тойрог	Нийт санхүүжилтийн дүн	Санхүүжилтийн дүн							
			Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр			1.1 Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	Үүнээс:		1.4 Иргэний хандив	Үүнээс:	
	А	1	2	3	4	5	6	7	8	1.3.1 Мөнгөн хандив	1.3.2 Мөнгөн бус хандив	11	1.4.1 Мөнгөн хандив	1.4.2 Мөнгөн бус хандив
1	Бор-Өндөр	МАН	Санчир	Угтахбаяр	2	-			-			-		
2	Бор-Өндөр	МАН	Базар	Оюун-Эрдэнэ	3	-			-			-		
3	Дэлгэрхаан	МАН	Юра	Батбаяр	3	-			-			-		
4	Батноров	МАН	Бөхчулуун	Мөнх-Одон		-			-			-		
5	Норовлин	МАН	Түмэнцогт	Чанцалдулам	4	-			-			-		
6	Батширээт	МАН	Гомбодорж	Гансүх	4	-			-			-		
7	Дархан	МАН	Оюунцэцэг	Золжаргал	1	-			-			-		
8	Батширээт	АН	Балжинням	Ариунаа	4	-			-			-		
9	Бор-Өндөр	АН	Чулуунбаатар	Батхөлөг		-			-			-		
10	Бор-Өндөр	АН	Энх-Амгалан	Азжаргал		-			-			-		
11	Дархан	АН	Александр	Жимсээ	1	-			-			-		
12	Дэлгэрхаан	АН	Баярсайхан	Мөнхболд	3	-			-			-		
13	Норовлин	АН	Мөрөнбаяр	Ням-Эрдэнэ	4	-			-			-		
14	Батноров	АН	Намжил	Наранцэцэг		1.0		1.0	-			-		
15	Бор-Өндөр	ХҮН	Сэр-Од	Гансонгууль		1,100.0	1,000.0		-			100.0	100.0	
16	Бор-Өндөр	ХҮН	Баасанжав	Алтансүх		1,250.0	1,000.0		-			250.0	250.0	
				ДҮН	10	2,351.0	2,000.0	1.0	-	-	-	350.0	350.0	-

Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дүн

/мян.төг/

№	Аймаг, сумын нэр	Намын нэр	Нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Нэр дэвшсэн тойрог	Нийт зардлын дүн	Сонгуулийн зардал								Бусад зардлын дүн	Үлдэгдэл
							сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	цахим орчин ашиглах зардал	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
	А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
4	Бор-Өндөр	МАН	Санчир	Угтахбаяр	2	-										-
5	Бор-Өндөр	МАН	Базар	Оюун-Эрдэнэ	3	-										-
6	Дэлгэрхаан	МАН	Юра	Батбаяр	3	-										-
7	Батноров	МАН	Бөхчулуун	Мөнх-Одон		-										-
8	Норовлин	МАН	Түмэнцогт	Чанцалдулам	4	-										-
9	Батширээт	МАН	Гомбодорж	Гансүх	4	-										-
10	Дархан	МАН	Оюунцэцэг	Золжаргал	1	-										-
11	Батширээт	АН	Балжинням	Ариунаа	4	-										-
12	Бор-Өндөр	АН	Чулуунбаатар	Батхөлөг		-										-
13	Бор-Өндөр	АН	Энх-Амгалан	Азжаргал		-										-
14	Дархан	АН	Александр	Жимсээ	1	-										-
15	Дэлгэрхаан	АН	Баярсайхан	Мөнхболд	3	-										-
16	Норовлин	АН	Мөрөнбаяр	Ням-Эрдэнэ	4	-										-
17	Батноров	АН	Намжил	Наранцэцэг		1.0									1.0	-
18	Бор-Өндөр	ХҮН	Сэр-Од	Гансонгууль		1,100.0	998.0		50.0		50.0				1.4	0.6
19	Бор-Өндөр	ХҮН	Баасанжав	Алтансүх		1,250.0		24.0			1,224.8				1.2	-
				ДҮН	10	2,351.0	998.0	24.0	50.0	-	1,274.8	-	-	-	3.6	0.6